



ДУНДГОВЬ АЙМГИЙН
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 01 өдөр

Дугаар А/21

Онги

Хөрөнгө зарцуулах тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1 дэх заалт, Монгол улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 02 тоот тогтоол, Байгаль хамгаалах сангийн зарцуулалтыг батлах тухай Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 68 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сайхан-Овоо сумын Онги багийн нутаг Цогт уул, Ахар уул агнуурын бүс нутагт нутагшин амьдарч байгаа Аргал, Янгирт хужир, өвс тавьж биотехникийн арга хэмжээг зохион байгуулсан ажлын үр дүнг хянах ан амьтаны эргүүл хамгаалалтын ажлыг гүйцэтгэж ажиллахыг Байгаль орчны хяналтын улсын байцаагч (Ц.Тунгалаг), Онги багийн Засаг дарга (Г.Пүрэв) нарт даалгасугай.

2.Хяналт шалгалт, эргүүл хамгаалал хийх шатахууны зардалд 120,300 (Нэг зуун хорин мянга гурван зуун) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах сангаас гаргахыг нягтлан бодогч (Г.Чагдарсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМАРСАНАА